

САЙНМЭДЭЭ ТАРААЛТЫГ ДАХИН ТӨСӨӨЛӨХ НЬ

БИБЛИЙН ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА



ЦУГЛАРАЛТ 1: АЙДСУУД

ЭХЛЭЛ

Хүн бүрийг цугларалтанд ирсэнд талархаад нэг нэгнийгээ хараахан мэдэхгүй бол хүн бүрийг бусдадаа өөрийгөө танилцуулж өгөхийг уриарай.

Цугларалтаа залбирлаар эхлэ.

Ирсэн бүх хүмүүс энэ асуултанд хариулж, тунгаан бодох хэрэгтэй: “Сайнмэдээ Тараалт” (Evangelism) гэдэг үгсийг сонсоход юу бодогдож байна вэ? Үүний тухай тунгаан бодоод, тодорхойлох нэг гол үг юмуу холбоо үг олохыг уриалаарай. Юуг бодогдуулж, санаанд нь буулгадаг вэ? Сэтгэгдлүүдийг цаасан самбар дээр тэмдэглэж авбал дараагийн цугларалтад эргэн харах боломжтой болно.

Сайнмэдээ тараалт нь “Өөртөө хийхгүйгээ бусдад хийж өгөх” гэж хэлэхийг та сонсож байснаа бүлэгтэйгээ хуваалцаарай.

Энэ тайлбар нь тэдэнд ямар сэтгэгдэл төрүүлж байгааг, мөн энэ нь тэдний санаа бодолтой нийцэж байгаа эсэхийг асуу.

СЭДЭВТЭЭ ОЙРТОХ НЬ

Оролцогчдод дараах асуултыг дотроо бодож тунгаах цаг өгөөрэй:

- Сайнмэдээ тараалттай холбоотой хамгийн онцгүй дурсамж тань юу байв?
- Юу ийм тааламжгүй дурсамж үлдээхэд хүргэсэн бэ?
- Сайнмэдээ тараах тухай бодоход ямар айдас төрж байна вэ?

Хувьдаа бодож үзсэнийхээ дараа, хамтрагч сонгож бодсон зүйлсээ хуваалц гэж хэлээрэй.

Санал бодлоо хоёр хоёроороо хуваалцаж дууссаны дараа хүсвэл бүлгийнхээ бусад хүмүүст хуваалцахыг уриалаарай.

Ярьсан бүх зүйлээ, эсвэл болсон явдлыг бүгдийг нь ярих шаардлагагүй гэдгийг тэдэнд сануул. Харин сонссон зүйлээ дүгнэн ярьж болно. Онцгойлон тэд ямар айдсуудтай нүүр тулсан тухай яриулаарай. Бүх багууд ярьж дууссаны дараа айдас болон сөрөг үйл явдлын тухай, мөн тэдгээрийг хэрхэх тухай үлдсэн хичээлийн цагийн туршид судлахыг сануулаарай.

БИБЛИЭС УНШИХ

Египетээс гарсан нь 4:10-17-г унш. (Мосегийн дуудагдсан түүхийн тухай). Энэ хэсгийг уншаад хамгийн түрүүнд юу бодогдсоноо хуваалцахыг хүсээрэй.

- Мосе юунаас айсан бэ?
- Бурханд ямар шалтгаан тоочсон бэ?
- Бурхан Мосед хэрхэн хариулсан бэ?

Мосе өөрийгөө шүүмжлэхдээ л анхаарсан байсан тул Бурханы хий гэсэн ажлыг хийхэд өөрийгөө хангалтгүй гэж дүгнэсэн гэдгийг бүлэгт сануул. Өөрийгөө шүүмжилж, голж байсан удаа бий юу? Тэр тусмаа сайнмэдээг дамжуулах үедээ ингэж байсан эсэхийг дор бүрдээ бодох цаг тэдэнд өгөөрэй. Бид бүгд сайныг хийхээр Бурханаар дуудагдсан ба Бурхан бидний амьдралын хором бүрт ажлаа хийсээр байгаа гэдгийг бүгдээрээ батлан ярилцаарай.

Одоо тэд өөрсдийн амьдралын туршлага дээр бодож үзэх боломж байгаа гэдгийг хэлээрэй. Хүн болгонд намтар түүх бий гэдгийг батла. Оролцогчид тус бүрдээ тунгаан бичихдээ цагаан цаасан дээр эсвэл том самбаран цаас болон маркер ашиглаж болно. Амьдралдаа болсон гол үйл явдлуудаа тэмдэглэж цагийн шугам адил хооронд нь зураасаар холбохыг заагаарай.

- Эргээд харахад Бурхан тэдний амьдралд хэрхэн ажилласан байна вэ?
- Бурхан тэдний амьдралд ажиллаж буйгаа тодорхой харуулж өгсөн амьдралын туршлагаа хуваалцах хүн байна уу?

Амьдралынхаа газрын зургийг дараагийн уулзалт хүртлээ хадгал.

ТӨГСГӨЛ

Хүн бүрийг цугларалтанд ирсэнд талархаад нэг нэгнийгээ хараахан мэдэхгүй бол хүн бүрийг бусдадаа өөрийгөө танилцуулж өгөхийг уриарай.

ЦУГЛАРАЛТ 2: ДОГДЛОЛ

ЭХЛЭЛ

Хүн бүрийг цугларалтанд нь дахин уриад, залбирлаар эхлүүлээрэй.

Нэгэн хүний хэлсэн үгнээс эш татан эхэлцгээе.

“Айдас ба догдлолын хоорондох ганц л ялгаа байдаг нь чиний өөрийн хандлага юм.”

Энэ эшлэлийг уншаад бүлгийнхэндээ санаа бодлоо хуваалцахыг уриарай. Догдлол гээд ярихаар бүлэг тань ямар “хандлага”-тай байсан байж болох вэ?

СЭДЭВТЭЭ ОЙРТОХ НЬ

СОНГОЛТ 1:

Өмнөх хичээл дээр хийсэн амьдралынхаа газрын зургийг дахин харж тунгаах цаг өгнө. Амьдралынх нь аль хэсэгт догдлол баяр хөөр байсан тухай бодож үзэхийг санал болгоорой. Тэгээд тэд хамтрагч сонгож энэ тухайгаа хуваалцаж болно. Цаг байвал хүн бүр амьдралынхаа догдлолоор дүүрэн мөчөө бусдадаа товчхон хуваалцаж болох юм.

СОНГОЛТ 2:

Арай өөрөөр хиее гэвэл эсвэл тухайн хүмүүс эхний хичээлд байгаагүй бол эсвэл хүн болгон амьдралын гол үйл явдлуудтай шугаман зургаа бэлтгэх боломж олдоогүй бол тэднээс хэзээ ямар нэгэн юманд маш их сэтгэл нь хөдлөж байсан тухай асуугаарай.

- Сэтгэлийг ихээр догдлуулсан ямар зүйл болж байсан бэ?
- Сэтгэл догдлолоо хэрхэн бусадтай хуваалцсан бэ?
- Тэдний мэдрэхүй (харах, үнэрлэх, хүрэх, амтлах, сонсох) тэр сэтгэл хөдлөлд хэрхэн оролцсон бэ?

Үүнийгээ хамтрагчдаа хуваалцахыг уриарай. Хоёр хоёроороо хуваалцсаны дараа бүгдэд хуваалцах боломж бас олгоорой.

БИБЛИЭС УНШИХ

Лук 9:18-20-ийг унш (Есүс Петрээс өөрийг нь хүмүүс хэн гэж байгаа талаар асуусан тухай). Энэ хэсгийг уншаад хамгийн түрүүнд юу бодогдсоноо хуваалцахыг уриарай.

- Есүсийн өөрийг нь хэн гэж байна вэ гэсэн асуултад дагалдагч нар нь яаж хариулсан бэ?
- Есүс яагаад ийм асуултыг дагалдагч нараасаа асуух болсон гэж бодож байна?
- Петр Есүсийг “Бурхан” гэж хэлсэн нь хэр чухал байсан гэж бодож байна? Яагаад чухал эсвэл чухал биш вэ?

СЭДЭВТ ХАРИУ ҮЙЛДЭЛ ҮЗҮҮЛЭХ НЬ

Библи дээр хүмүүс Есүсийг хэн болох тухай гайхаж бас асууж байсан нь зөвхөн Лук 9:18-20-д гардаггүй гэдгийг бүлгийнхэнтэйгээ хамт нотлоорой. Библийн цаг үед яагаад хүмүүс Есүсийн хэн болох тухай асуусаар л байсан гэж бодож байна? Библийн энэ хэсэг нь Есүс 5000 хүнийг гайхамшигтайгаар хооллосны дараа гардаг гэдгийг бүлгийнхэндээ сануул.

- Есүсийн тухай ярианд тэр бодит гайхамшиг хэрхэн нөлөөлсөн байж болох вэ?
- Одоо ямар амьдралын үйл явдал Есүсийн тухай ярихад хүргэн нөлөөллөх бол?

Есүс тэдний хувьд хэн болох талаар судлах цаг гаргана гэдгийг бүлгийнхэндээ хэлээрэй. Үүнийг хэрхэн хийх сонголтууд бий.

СОНГОЛТ 1:

Хоосон цаасны голд “Есүс” гэж бичээд түүнийг тойруулан тойргууд зур. Тэгээд голд байгаа үгнээс гадагш чиглэсэн зураас татаж нэг үг эсвэл холбоо үгээр Есүс гэж хэн болох тухай тодорхойлон бич. Мөн бичсэн үгнүүдээ эсвэл холбоо үгсээ хооронд нь зураасаар холбож болно бас гадагш чиглэсэн шинэ зураасууд татаж болно. Өөр холбоосууд үүсгэж шинэ үг нэмэх болгондоо гадагш чиглэсэн зураас татаж болох юм.

Тэд бодсон бүх зүйлээ бичээд дууссаных нь дараа зурсан зүйл рүүгээ харахыг уриарай. Тэд Есүс хэн бэ гэдгийг хэрхэн тайлбарласан байна вэ? Цөөн хэдэн өгүүлбэрээр түүний тухай тэд юу хэлж чадах вэ?

СОНГОЛТ 2:

Хүмүүсээр Есүс хэн болох тухай тэмдэглэл бичүүлээрэй. Тэд яаж эхлэхээ мэдэхгүй байвал дараах асуултуудаар санаагаа илэрхийлж болох юм:

- Есүс хэн болох тухай анхны ойлголт нь ямар байсан бэ? Цаг хугацаа өнгөрөхөд тэр ойлголт тань өөрчлөгдөж эсвэл хөгжсөн үү?
- Есүсийн тухай Библид гардаг хамгийн ойлголт буусан эшлэл юу вэ?
- Есүсийн хэлсэн үгсээс аль нь тэднийг шалгасан эсвэл тэдэнд хэцүү байсан бэ?
- Есүсийн юу нь танд хамгийн сэтгэл догдлом байсан бэ?
- Есүсийг хэдэн өгүүлбэрээр тайлбарла гэвэл юу гэж хэлэх вэ?

ТӨГСГӨЛ

Энэ хичээлээр сурсан гол зүйлсээ тунгаан бодохыг уриалаарай. Тэдэнд догдлол болон баяр хөөрийн тухай хуваалцах өөр зүйлс байна уу? Есүс тэдний хувьд хэн болох тухай хүмүүс өөр юу гэж хуваалцахыг хүсэж байна вэ?

Цугларалтаа залбирлаар дуусгаарай.

ЦУГЛАРАЛТ 3: ХАМТ ОЛОН

ЭХЛЭЛ

Цугларалтаа залбирлаар эхлэ.

Нэгэн хүний хэлсэн үгнээс эш татан эхэлцгээе.

“Хамт олныг бүтээх гэдэг нь амьдралаа чиглүүлэхэд тустай тусламжийг хүлээн авах чухал хэсэг юм.”

Энэ эшлэлийг уншаад санаа бодлоо хуваалцахыг, мөн тэд үүнтэй санал нийлж байгаа эсэхийг асуу. Хэрхэн хамт олон “бүрэлдэж” болох вэ?

СЭДЭВТЭЭ ОЙРТОХ НЬ

СОНГОЛТ 1:

Өмнөх цугларалтаас Есүсийг хэн болох тухай бичиж тэмдэглэсэн зүйлсээсээ нэг гол санааг бүлгийнхэндээ ярьж өгөхийг уриарай. Тэд бичгэн эсвэл зурган тэмдэглэлээсээ аль алианаас нь хуваалцаж болно. Хүмүүс өөрсдийн дүгнэлтээсээ бүлэг дундаа хуваалцаж болно. Дараа нь эдгээр асуултуудыг тунгаан бодох хэрэгтэй.

- Нэгнээ дэмждэг хамт олны хүрээнд Есүсийн тухай сэтгэл догдлолоо хуваалцах нь ямар байна вэ?
- Есүсийн хувьд хамт олны хүрээллийн тухай ойлголт ямар байсан бэ?
- “Хамт олон” гэж юу гэсэн утгатай вэ?

СОНГОЛТ 2:

Хэрэв тухайн хүмүүс сүүлийн цугларалтад байгаагүй бол эсвэл бүх хүмүүс Есүс тэдний хувьд хэн болох тухай тунгаах цаг гараагүй бол дараах зүйлсийг олж мэдэх хэрэгтэй.

- “Хамт олон” гэж юу вэ?
- Хамт олноосоо тусламж, дэмжлэг авч байсан удаа бий юу? Тийм бол хэдэн жишээ хуваалцаарай.
- Үлгэр жишээ хамт олон ямар байх ёстой вэ?

3,3-аараа баг болон асуултуудад хариулан ярилцаарай. Дараа нь баг бүрээс нийт дундаа өөрсдийн зарим санаа бодлоо хуваалцаарай.

БИБЛИЭС УНШИХ

Естер 4:5-17-г унш. (Естер нийгэмдээ хэрхэн хариу үйлдэл үзүүлж буй тухай) Библийн энэ хэсгийг уншаад бодогдсон зүйлсээ хуваалцана.

- Естер нийгэмдээ болоод тухайн нөхцөлд ямар хариу үйлдэл үзүүлсэн бэ?
- Энэ түүхэнд ямар харилцаа чухал байсан байна вэ? Хэн хэн холбоотой байсан бэ?
- “Хэрэв чи энэ үед” (эшлэл 14) гэсэн нь ямар утгатай үг вэ?

СЭДЭВТ ХАРИУ ҮЙЛДЭЛ ҮЗҮҮЛЭХ НЬ

Естер тухайн цаг үе, тухайн газарт дуу хоолойгоо өргөхөөр Бурханаар дуудагдсан байсан. Энэ түүхэнд гэхдээ зөвхөн Бурханы дуу хоолой биш бусад хүмүүсийн ард түмнийг нь устгах дуу хоолой ч байсан. Энэ бүх дуу хоолой дундаас Естер Бурханы ажлын дуудлагыг сонссон.

- Бурханы дуу хоолой ба Бурханы дуудлагыг сонсох гэдэг нь чиний хувьд ямар утга учиртай вэ?
- Өөр бусдын дуу хоолой дундаас яаж Бурханы дуу хоолойг чих тавин сонсох вэ?
- Естер нийгмийн хүрээлэлдээ өөрийн дуудлагаа ямар аргаар хэрэгжүүлсэн гэж бодож байна вэ?

Естерийн дуудагдсан түүх нь нэг талаараа хэт дэврүүн гэж бодолгүйгээр харин тэрээр дуудлагаа ойлгон нийгмийн хүрээлэл дундаа хэрэгжүүлсэн гэдгийг нь онцлон үзэхийг бүлгийнхэндээ уриал.

- Бид хэрхэн бусдын хувьд Естер шиг байж болох вэ? (Бурханы дуудлагыг сонсож, зөв цагт ярих)

Естер дуудлагаа хүлээн авч өөрийн нийгэмдээ нөлөөлсөн. Бүлгийнхэнд дараах асуултыг өгч, хоорондоо ярилцсаны дараа

түүхийг дахин нэгтгэх даалгавар өгөөрэй.

- Бурханы дуудлага таны амьдралд ямар учир утгатай вэ?
- Амьдралдаа Бурханы дуу хоолойг хэрхэн сонсож байсан бэ?
- Хамт олон эсвэл нийгэм таны итгэлийн амьдралд хэр их хэсгийг эзэлдэг вэ?

Хүн бүрийг энэ асуултуудад хариулахдаа өөрийнхөө итгэлийн амьдралын тухай ярихдаа бэлтгэн бичихийг уриарай.

Бүлгийнхнээс өөрсдийн гэрчлэлийг Эзэний өдрийн хүндэтгэл дээр хуваалцах хүсэлтэй хүн байгаа эсэхийг асуугаарай!

ТӨГСГӨЛ

Өнөөдрийн хичээлээр сурсан гол зүйлсээ тунгаан бодохыг уриалаарай. Хамт олон болон дуудлагын тухай өөр ярих зүйлс тэдэнд байна уу? Зөв цагтаа ярих тухай өөр нэмэлт санаа бодол байна уу?

Цугларалтаа залбирлаар дуусгаарай.

ЦУГЛАРАЛТ 4: ӨӨРЧЛӨЛТҮҮД

ЭХЛЭЛ

Цугларалтаа залбирлаар эхлэ.

Дараах эшлэлүүдийг бүлгийнхэндээ хуваалцаарай.

“Бид өөрлөгдөхгүй бол өсөхгүй. Хэрэв өсөхгүй бол бид үнэндээ амьдарч байгаа юм биш.” – Гейл Шийхи

“Өөрчлөлтийн анхны алхам бол өөрчлөлт хэрэгтэйг мэдэх. Хоёр дахь алхам нь хүлээн зөвшөөрөх явдал юм.” – Натаниел Бэнди

Энэ эшлэлийг уншаад санаа бодлоо хуваалцахыг, мөн тэд үүнтэй санал нийлж байгаа эсэхийг асуу. Хэрвээ өөрчлөлт нь бялхам амьдралтай холбоотой юм бол бид яагаад өөрчлөлт

хийхээс татгалздаг юм бэ?

СЭДЭВТЭЭ ОЙРТОХ НЬ

СОНГОЛТ 1:

Уриалах: Хоёр эсвэл гурваараа баг үүсгэн өнгөрсөн долоо хоногт ярилцсан итгэлийн амьдралынхаа тухай, мөн өөрсдийн итгэлийн аялалд Бурханы дуу хоолой болон хамт олныхоо дунд гүйцэтгэх таны үүргийн давхцал хаана байсан тухай ярилцаарай.

СОНГОЛТ 2:

Өөр нэг нь, хэрэв тухайн хүмүүс сүүлийн цугларалтад байгаагүй бол эсвэл бүх хүмүүс итгэлийн амьдралынхаа тухай бичиж бэлтгэх цаг гараагүй бол дараах зүйлсийг олж мэдэж болох юм.

- Амьдралдаа өөрчлөлт хийхэд хамгийн хэцүү байсан цаг үе чинь хэзээ вэ?
- Ямар талбарт өөрчлөлт хийхэд амархан эсвэл бүр хялбархан гэж хэлж болохуйц байдаг вэ?
- Тэгвэл яагаад цуглаанд өөрчлөлт хийх тэр тусмаа хэцүү байдаг вэ?

БИБЛИЭС УНШИХ

Үйлс 9:1-15-г унш. (Паулын өөрчлөгдсөн түүх). Библийн энэ хэсгийг уншаад бодогдсон зүйлсээ хуваалцана.

- Түүхэнд Саулын анхны зорилго болон дараа нь хүлээж авсан даалгавар нь юу байсан бэ?
- Есүс Саулд зөвхөн хийж байгаа зүйлээ зогсоо гэж хэлээгүй, харин бүр өөрийнх нь хийж байсан, итгэж, зааж байснаас яг эсрэгээр үйлдэхийг тушаасан. Саул тэр үед юу бодож байсан бол?
- Чи Ананиагийн оронд байсан бол Есүсийн үгэнд юу гэж хариулах байсан бэ?

СЭДЭВТ ХАРИУ ҮЙЛДЭЛ ҮЗҮҮЛЭХ НЬ

Саул бол үзэл бодол, итгэлдээ бат зогсдог шашны удирдагч байсан. Гэтэл Есүс Саулыг хийж буй ажлаа орхи гэж хэлээд зогсохгүй хавчин дарамталж байсан хүмүүсээ удирдаарай гэсэн. Тэр үед Ананиа өөрт нь хор хүргэхээр ирж байсан Саулыг хүлээн авч, дагалдуулах дуудлагыг авчээ. Бид үүнийг зөвхөн Саулын өөрчлөлт гэж боддог боловч энэ түүхэнд хоёр хүний дуудлага ба өөрчлөлт гардаг.

- Бидний ихэнх нь өөрчлөлт гэдэг нь ямар нэгэн итгэл үнэмшлийг хүлээн зөвшөөрөх гэж боддог. Гэтэл Есүс Саулыг үйлдэлд дуудсан. Таны итгэл яаж таныг өөрөөр үйлдэхэд хүргэж байсан бэ?
- Дамаск хүрэх замд тохиолдсон зүйлээс өмнө Саул өөрийгөө зөв юм хийж байгаа гэдэгтээ бат итгэлтэй байсан. Чиний хүсэл тэмүүлэл Бурханы хүслээс өөр байснаас болж өөрчлөлт орж байсан удаа амьдралд тань бий юу?
- Бурхан шинэ зүйлийг хийхийн тулд Өөрийн төлөвлөгөөний дагуу тэднийг ашиглаж байгаа гэж итгэж хүлээн авахад хэцүү хүмүүс таны ч амьдралд байна уу?

Саулын амьдрал гайхам, сонин үйл явдлаар дүүрэн байсан ч олон нийтийн үйлчлэлээ тэр дороо эхлүүлээгүй. Дамаск хүрэх зам болон түүний анхны сайн мэдээний аян зам эхлэх хооронд хэдэн жил өнгөрсөн. Учир нь түүнд Христийн сайд болон үйлчлэхээсээ өмнө Есүстэй хамт цагийг өнгөрөөж, Түүнийг танин мэдэх цаг хэрэгтэй байсан.

- Таны хувийн амьдралд эсвэл үйлчлэлийн орчинд Есүстэй хамт байх, танин мэдэх цагийг авдаг ямар газрууд байдаг вэ?
- Энэ түүхээр бидэнд Бурхан бидний “үгүй”-нүүдийг, “бид хэзээ ч ингэж хийж үзээгүй”-нүүдийг авч, бидэнд юмсыг шинээр харж, бүтээж, бас үйлдэх өөрчлөлтийг авчирдаг. Хувийн амьдралд болоод чуулганыхаа аль талбаруудад бид байгаа зүйлээ тавьж явуулж Бурханы өөрчлөлтийн хүчийг ажиллахыг зөвшөөрөх хэрэгтэй байна вэ?

ТӨГСГӨЛ

Энэ хичээлээр сурсан гол зүйлсээ тунгаан бодохыг уриалаарай. Тэдэнд Бурханы дуудлагыг танин мэдэх эсвэл өөрчлөлт хийх тухай хуваалцах өөр зүйлс байна уу?

Цугларалтаа залбирлаар дуусгаарай.

ЦУГЛАРАЛТ 5: ҮГС

ЭХЛЭЛ

Цугларалтаа залбирлаар эхлэ.

Ариун Францисийн хэлсэн үгнээс эш татан бүлгийнхэндээ хуваалц.

“Сайнмэдээг бүх цаг үед тараа. Хэрэгтэй бол үг ашигла.”

Энэ эшлэлийг уншаад бүлгийнхэн юу гэж бодсон, мөн тэд үүнтэй санал нийлж байгаа эсэхийг асуу.

СЭДЭВТЭЭ ОЙРТОХ НЬ

Оролцогчдод дараах асуултыг чимээгүй бодож тунгаах цаг олгоорой.

- Сайнмэдээг үггүйгээр тунхаглах ямар арга замууд байна вэ?
- Та сайнмэдээг үгээр тунхаглах дуртай юу эсвэл үйлдлээр үү? Яагаад?

Гурван хүнтэй баг бүрдүүлж санаа бодлоо хуваалцаарай. Дараа нь бүлгийнхэндээ багийнхаа санаа бодлыг товчхон хуваалцаж болно.

БИБЛИЭС УНШИХ

Рут 1:15-22-г унш. (Рут, Ноами хоёрын түүх). Библийн энэ хэсгийг уншаад бодогдсон зүйлсээ хуваалцана уу.

- Яагаад Рут өөрийн нутаг орноо орхин Наомиг дагахаар шийдсэн бэ?
- Зовлон зүүдүүр, үр хүүхдээ алдсан байх тэр үед, Рут Бурханы тухай түүхийг, үгүй юм аа гэхэд Наомигийн Бурхантай харилцах харилцааг, олж харан сэтгэл татагдсан. Бурхан хэрхэн тийм үржил шимгүй бас боломжгүй мэт харагдах газар найдварын үгээ хэлсэн бэ?

СЭДЭВТ ХАРИУ ҮЙЛДЭЛ ҮЗҮҮЛЭХ НЬ

Еврей шашны итгэл, онцлог шинж чанарыг Рут өөртөө хүлээн зөвшөөрөхөөсөө өмнө, Наомигийн итгэлийн уламжлал болон тэдний ард түмэнд харьяалагддаг юм шиг аль хэдийн мэдэрдэг болсон байжээ. Гарцаагүй, Рутад махан биеийн өдөр тутмын хэрэгцээ байсан хэдий ч, түүнээс гадна гэр бүл хамт олонтой байх буюу дотны хүмүүсийн нэгдэл дотор байх хэрэгцээ ч байсан юм.

- Христитгэлээр амьдрах цаг хугацаанд тань таныг нэг хэсэг нь болж хамааралтай хүн гэдгээ мэдрэхэд тусласан хүмүүс хэн байсан бэ?
- Та хэн нэгэнд Наоми шиг үйлчилж байсан уу?
- Та хэн нэгэнд Бурханы хайр болон оршихуй тэдний амьдралд ч байгаа гэдгийг мэдрэхэд нь туслаж байсан уу?

Бүлгийнхэндээ дараах зүйлсийг тунгаан бодохыг уриалаарай:

- Сүүлийн үеийн судалгаанууд олон цуглааныхан сайныг үйлдэх гэдгийг хэрхэн ялгаж ойлгохоор зүдэж байгааг харуулдаг. Энэ нь зүгээр л хийхэд “сайхан” зүйл болохоор эсвэл нийгэмдээ хүлээсэн үүрэг гэдэг. Гэтэл нөгөөтэйгүүр хайрын улмаас болон Бурханы хайрын хариуд үйлчлэх нь зүй ёсных зэрэг байж болох юм. Таны хувьд үйлчлэх урам зориг тань юу вэ?
- Та үйлчилж байхдаа хувийн харилцааг бий болгохыг эрмэлздэг үү эсвэл ихэнхдээ тухайн хүний бодит хэрэгцээг олж харж хангахыг хичээдэг үү?
- Хүн бүрийн хэрэгцээ, хүсэж буй зүйлсийг нэгдмэл гэж харвал бусдад хүрч үйлчлэх маань хэрхэн өөр болох байсан бол? Үүнд: биеийн, нийгмийн, сэтгэл зүйн, сүнслэг

хэрэгцээнүүдийг багтааж байгаа юм. Хэрэв хэн нэгэн санхүүгийн хувьд хангалттай байдаг ч өөр талбарт гүн гүнзгий хангагдаагүй хүсэл хэрэгцээ байгааг нь олж харвал яах вэ?

ТӨГСГӨЛ

Энэ хичээлээр сурсан гол зүйлсээ тунгаан бодохыг уриалаарай. Бусдад Бурханы хайрыг мэдрүүлэх тухай хуваалцах өөр зүйлс бүлгийнхэнд байна уу? Бурханы хайрын хариуд үйлчлэх тухай өөр санал бодол байна уу?

Цугларалтаа залбирлаар дуусгаарай.

ЦУГЛАРАЛТ 6: ЯВ

ЭХЛЭЛ

Цугларалтаа залбирлаар эхлэ.

Тереса эхийн хэлсэн үгнээс эш татан бүлгийнхэндээ хуваалц.

“Хайрын захиаг сонсохыг хүсвэл илгээх хэрэгтэй. Дэнлүүг асаалттай байлгахын тулд тос нэмсээр байх хэрэгтэй.”

Энэ эшлэлийг уншаад санаа бодлоо хуваалцахыг, мөн тэд үүнтэй санал нийлж байгаа эсэхийг асуу.

СЭДЭВТЭЭ ОЙРТОХ НЬ

Оролцогчдод дараах асуултыг чимээгүй бодож тунгаах цаг олгоорой.

- Бид өөрсдийгөө хэрхэн илгээгдсэн хүмүүс гэдгээр ойлгох вэ?
- Та нийгэмд хаана хаана хайрын захиаг ашиглаж болох вэ?

Гурван хүнтэй баг бүрдүүлж санаа бодлоо хуваалцаарай. Дараа нь бүлгийнхэндээ багийнхаа санаа бодлыг товчхон хуваалцаж болно.

БИБЛИЭС УНШИХ

Матай 28:16-20-г унш. (Агуу Захирамж). Библийн энэ хэсгийг уншаад бодогдсон зүйлсээ хуваалцана уу.

- Есүсийн Матай номон дээр дагалдагчиддаа хэлсэн сүүлийн үгс нь зөвхөн хариуцлага биш харин амлалт юм. Бид Есүсийн ажлыг үргэлжлүүлэх үүрэг хариуцлагыг хүлээн авсан. Агуу Захирамжийн юу нь танд хамгийн хүч сорьсон мэт санагдаж байна вэ?
- “Яв” гэдэг Грек үгээр нь яг ч биеэр явж очихыг онцлоогүй. Харин даруй Есүсийн үг хэрэгтэй байгаа газруудыг хэлсэн байдаг. Бид эдгээр үгсийг уншихдаа хайхрамжгүй хандаж байна уу эсвэл хойшлуулшгүй шаардлагыг мэдэрч байна уу?
- Есүс бидэнд Түүний өмнөөс үйлчлэх эрх мэдлийг өгсөн ба бид хэзээ ч ганцаараа биш гэдгийг энэ эшлэл сануулж байгаа юм. Өөрөөр хэлбэл, Есүс бүхий л нөхцөл байдалд аль хэдийн ажилласаар байдаг. Харин Түүний хаанчлалын ажилд бид уригдсан гэсэн үг. Энэ мэдлэг Бурханы ажлыг хийхэд танд тулгардаг айдсыг тань арай багасгаж байна уу?

СЭДЭВТ ХАРИУ ҮЙЛДЭЛ ҮЗҮҮЛЭХ НЬ

Манай урсгалын эрхэм зорилгын “Дэлхийн өөрчлөлтийн төлөө Есүс Христийн дагалдагчдийг бүтээнэ” гэдэг хэсэг нь Агуу Захирамжаас бүтсэн.

- Сүүлийн хэдэн арван жилд цуглаанууд илүү гишүүд сайтай болохыг зорьж Есүс Христийн дагалдагчид бэлтгэхийг орхигдуулж байна. Гишүүнчлэл болон Дагалдагч бэлтгэхийн ялгааг та ойлгож байна уу?
- Цуглаанд гишүүнчлэлийг Христ итгэлийн зорилго гэж харж байна уу? Эсвэл энэ нь дэлхийг өөрчлөхийн тулд нэг Бурханыг хайрлах хайр болоод мэдлэг дотор нэг бие болж хамтдаа өсөх суваг хэмээн үзэж байна уу?
- Цуглаан болон урсгал чиглэлүүд гишүүдээ олноор алдаж байгаа энэ цагт, бид яаж айдсаа даван, яаж Бурхан ямар шинэ зүйлсийг хананы цаана хийж байгааг очиж харах боломжийг ашиглах вэ?
- Сайнмэдээ тараалтын нэг гол зүйл нь анхаарал хандуулах: Бурханд анхаараа хандуулах ба бусдад анхаарлаа

хандуулах. Бурхан хөршүүдэд тань ямар зүйл хийх гэж байгааг мэдэхийн тулд Бурханд ямар арга замаар анхаарлаа хандуулах вэ?

- Таны цуглаанд сайнмэдээ тараах боломжуудыг хэрхэн сонгодог вэ? Хэрэгцээ хаана байгааг таамаглаад, гишүүдийн сонирхолын дагуу, эсвэл үнэхээр л орчин тойрныхоо хүмүүсийнхээ дуу хоолой, илэрхийлсэн хэрэгцээнд суурилан сонгодог уу?

СОНГОЛТ 1

Энэ хичээлийг цуглаанийхаа нийт гишүүдэд зааж байгаа бол одоогоор цуглаандаа байгаа сайнмэдээ тараах арга болон бусдад хүрэх аргаа судлаж үзээрэй. Өөрийнхөө цуглааны сайнмэдээ тараалтыг тунгаан бодохдоо цуглаан өөрийн бүх л хүч чадал, бэлэг авьяасаа ашиглан нийгмийг холбох, тэдэнд найдварыг өгөх ажил хийж байна уу гэж асуугаад үзээрэй.

Тэр хүчин чармайлт нь танай хашаанаас гаднах хүн амд нөлөөлж байна уу? Эргэн тойрныхоо хүн ам зүйн тухай мэдээлэл олж аван, нийгэм рүүгээ чиглэх, ойр орчны хүмүүсийнхээ мөрөөдөл болон найдвар нь юу болох тухай иргэдийн удирдагч нартай ярих тухай бодож үзээрэй.

СОНГОЛТ 2

Оролцогчдийг “явахдаа” гэдэг үгийг өдөр бүрийн амьдралдаа тусган авахыг уриалаарай. Бүтэн долоо хоногийн багахан хэсэг нь л цуглаан дээр өнгөрдөг. Тодорхой цагийг өнгөрөөдөг өөр ямар газрууд байна вэ? Тэдний гэр, сургууль, ажил, хөршүүд болон өөр бусад цагаа өнгөөдөг газруудад ямар аргаар Бурханы хийж буй ажилд нэгдэн үйлчилж болох тухай цаг гарган бодож үзээрэй гэж зоригжуулаарай.

ТӨГСГӨЛ

Энэ хичээлээр сурсан гол зүйлсээ тунгаан бодохыг уриалаарай. Үлдэх эсвэл явах тухай хуваалцах өөр зүйлс бүлгийнхэнд байна уу?

Цугларалтаа залбирлаар дуусгаарай.

Энэ Библийн хичээлийг Дагалдагч Бэлтгэх Хорооны Сайнмэдээний Үйлчлэлийн захирал Хэатр Хэйнзмэн Лиа (Heather Heinzman Lear) болон Канадын Нэгдсэн Чуулганы Гэрчлэгч ба Дагалдагч Бэлтгэх багийн ахлагч Адел Халлидэй (Adele Halliday) бичсэн. Энэхүү хичээл нь Сайнмэдээний Холбоо (Evangelism Connections)-ноос 2016 онд эрхлэн гаргасан томоохон видео хичээлийн төслөөс гаргаж авсан хэсэг юм. Сайнмэдээний Холбоо нь сайнмэдээ тараалт, бүх хүнд нээлттэй нөхөрлөл, цуглааны амьдрах чадварыг 21 дүгээр зуунд биежүүлэхийн тулд нөөц бололцоог бусдадаа хуваалцахыг хичээн ажилладаг Хойд Америкийн христитгэгчдийн хамтарсан бүлэг юм. Есүсийн үг сургаалыг энэ цаг үед дэлхийд дамжуулахын тулд та бүгдийн оролцоо хэрэгтэй. Сэтгэгдэл, санал бодол, шинэ санаачлагаа бидэнтэй хуваалцаарай.

Зөвлөх гишүүд нь дараах урсгал чиглэлийн сайнмэдээний үйлчлэгчдээс бүрдсэн болно:

- Африкийн Методист Хамбын Сион Чуулган
- Америкийн Баптист Чуулганууд
- Христийн Чуулган (Христийн Дагалдагчид)
- Ах Дүүсийн Чуулган
- Хамбын Чуулган
- Америкийн Евангелийн Лютеран Чуулган
- Моравийн Хойд Аймгийн Чуулган
- Канад дахь Пресвитериан Чуулган
- Пресвитерийн Чуулган (АНУ)
- Америк дахь Шинэчлэгдсэн Чуулган
- Христийн Нэгдсэн Чуулган (АНУ)
- Канадын Нэгдсэн Чуулган
- Нэгдсэн Методист Чуулган (АНУ)

Сайнмэдээний Холбооны тухай илүү дэлгэрэнгүйг доорх цахим хаягаас: <http://www.evangelismconnections.org>.

Орчуулсан: Г. Цэвэлмаа

Хянасан: Н. Нандин-Эрдэнэ

Эмхэтгэсэн: Нэгдсэн Методист Чуулган

Хэвлэсэн газар: Монгол дахь Нэгдсэн Методист Чуулган

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 11-р хороо, Дэнжийн 1000-н гудамж,
24-р байр.

2019 он



DISCIPLESHIP MINISTRIES

The United Methodist Church

This and many other resources are available
for download and purchase at:

www.UMCdiscipleship.org

1908 Grand Avenue, Nashville, TN 37212

UMCdiscipleship.org

877.899.2780

info@UMCdiscipleship.org

COMXXX